

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.04.01-04.05

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индекс 2017 оноос хойш анх удаа 7 долоо хоног дараалан өсөв.

S&P 500 индексийн сагсанд багтдаг түүхий эд боловсруулагч болоод санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн бол ус, цахилгаан, дулаан хангамжийн компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

АНУ-ын аж үйлдвэр болон үйлчилгээний салбарт өсөлт гарсан байна. АНУ-ын хөдөлмөрийн яамны мэдээлснээр 3-р сард 196 мянган шинэ ажлын байр нэмэгдсэн нь таамаг хэмжээнээс өндөр байв. Нэг цагийн цалин хөлсний дундаж хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар өссөн ч, 2-р сарын түвшнээс 0.2 пүнтээр буурсан байна.

АНУ-аас импортолж буй автомашинд ногдуулах тарифын хариу арга хэмжээгээ дахин хойшлуулахаар болсноо БНХАУ-ын Засгийн газар мэдэгдлээ. Энэ нь энэ долоо хоногт үргэлжлэх хоёр талын худалдааны хэлэлцээнд таатай уур амьсгал нэмсэн мэдээлэл болж байна.

Европ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээрт ахиц гарснаар Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

BREXIT хэлэлцээрийн тодорхойгүй байдал нэмэгдсээр байна. Европын Зөвлөлийн Ерөнхийлөгч Дональд Туск BREXIT-ийн товыг урт хугацаагаар буюу 12 сараар хойшлуулах санал тавьж магадгүй байна. Их Британи Европын Холбооноос 3-р сарын 29-нд гарах товтой байсан ч Тереза Мэйн Засгийн газрын хүсэлтээр Европын Холбоо 50 дугаар тогтоолыг сунгаж, BREXIT-ийн товыг 4-р сарын 12 хүртэл хойшлуулсан юм. Тиймээс Их Британийн Парламент BREXIT-ийн асуудлаар яаралтай ямар нэг шийдэлд хүрэх шаардлагатай болж байгаа аж.

Фүнтийн ханш ам.долларын эсрэг 0.29 хувиар чангарч, 10 жилийн хугацаатай бондын өгөөж 1.12 хувиар өсжээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 3 орчим хувийн өсөлт үзүүлээ.

Японы төв банкаас томоохон компаниудын дунд улирал бүр явуулдаг санал асуулгаар Tankan индекс +19 нэгжээс +12 болж буурчээ. Харин шинжээчдийн урьдчилсан таамаг +14 нэгжтэй тэнцэж байв.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

БНХАУ “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд хийгдэх гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалтын журам боловсруулж байгаа талаар эх сурвалж мэдээллээ. Энэ нь БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жиньпиний гол бодлогыг илүү нарийн тодорхойлох анхны алхам болж байгаа ажээ. Одоогоор эцэслээгүй байгаа энэхүү зохицуулалтын хүрээнд компаниуд “Бүс ба Зам” санаачилгын нэрийг буруугаар ашиглахыг зогсоох зорилготой гэж эх сурвалжийн мэдээлэлд онцлов.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,108.70	-3.56% ▼
Dow Jones	АНУ	26,424.99	1.91% ▲
S&P 500	АНУ	2,892.74	2.06% ▲
Nasdaq	АНУ	7,938.69	2.71% ▲
S&P/TSX	Канад	16,396.15	1.83% ▲
FTSE 100	Их Британи	7,446.87	2.30% ▲
S&P/ASX 200	Австрали	6,181.30	0.01% ▲
Nikkei 225	Япон	21,807.50	2.84% ▲
Hang Seng	Хонг Конг	29,936.32	3.05% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.16
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.44
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.73
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.22
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.58
DBM' 2023	USD	7.250%	103.72
TDBM' 2020	USD	9.375%	104.41

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.471	-0.02 ▼
Libor 3M	2.592	-0.01 ▼
Libor 6M	2.644	-0.02 ▼
Libor 1YR	2.750	0.04 ▲
US 2YR Bond	2.325	0.03 ▲
US 3YR Bond	2.278	0.04 ▲
US 5YR Bond	2.295	0.03 ▲
US 10YR Bond	2.486	0.05 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.04.05	Өөрчлөлт
USD	2,631.58	0.00% ▲
CNY	391.76	0.04% ▲
EUR	2,954.61	-0.04% ▼
RUB	40.22	-0.98% ▼
KRW	2.31	-0.43% ▼
JPY	23.56	-0.84% ▼
CAD	1,970.63	0.59% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,291.76	-0.05% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	15.11	-0.06% ▼
Зэс	USD/lb.	289.45	-1.41% ▼
Нүүрс	USD/MT	80.80	-4.53% ▼
WTI газрын тос	USD/bbl.	63.08	4.89% ▲
Brent газрын тос	USD/bbl.	70.34	2.85% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.66	0.00% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. II	6.90%
Бодлогын хүү	2019. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. II	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. II	12.00%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. II	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. II	17.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. II	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 54 компанийн 575.4 сая төгрөгийн 3,455,346 ширхэг хувьцаа арилжигдав.

“Монгол савхи” /UYN/ компанийн хувьцаа 14.94%-аар буюу хамгийн ихээр өсч 577.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Баялаг налайх” /BNB/ компанийн хувьцаа 26.28%-аар буурч 245.5 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


4-р сарын 5-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,326.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,108.70 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 3.44%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоног, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	575.4
Зах зээлийн үнэлгээ	2,326,333.2

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,108.70	-3.44% ▼
MSE I индекс	8,857.01	-6.36% ▼
MSE II индекс	8,147.35	-2.10% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	217,993	134,449,150
Ард кредит ББСБ	1,644,490	130,380,672
Таван толгой	9,762	69,355,655
Говь	191,842	54,585,155
Түмэн шувуут	292,278	49,850,864

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол савхи	577.00	14.94% ▲
Хэрлэн хивс	78.00	14.71% ▲
Мон-ит булигаар	8,500.00	13.33% ▲
Авто импекс	2,600.00	13.04% ▲
Хай би ойл	54.89	9.78% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Баялаг налайх	245.50	-26.28% ▼
Тахь-ко	11,800.00	-14.86% ▼
Э-транс ложистикс	87.04	-14.67% ▼
Эрдэнэт авто зам	320.00	-13.51% ▼
Булган гурил тэжээл	800.00	-11.11% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард секюритиз	251,227,210
Голомт капитал	153,357,568
Бумбат-Алтай	127,487,923
Би Ди Сек	105,106,269
Ти Ди Би Капитал	93,968,021

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	570.21	606,807
Таван толгой	6,690.00	352,330
МИК	10,010.00	221,797
Говь	281.01	220,780
Сүү	209.07	71,920

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛендМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.05.01-ний дотор
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дютти фрийд ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мэх импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.05.01-ний дотор
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.01-с
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.12.31-ний дотор
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК санхүү, үйл ажиллагааны тайлан ирүүлээ

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD | MSE:ERDN) 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Хөндий Алтны Төслийн ажлын явц болон цаашдын төлөвлөгөөг танилцуулсан байна.

Тус компани 2019 оны 4-р сард Хөндий Алтны Дүүрэгт хэтийн төлөв бүхий талбайд хайгуул хийх, Урьдчилсан ТЭЗҮ-г дэмжих өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд жилд хамгийн багадаа 50,000 унц алт олборлох хүчин чадал бүхий өндөр агуулгатай ил уурхайг хөгжүүлэлтийн шатанд хүргэх, цаашид олборлолтын хэмжээг 100,000 унц хүргэх боломжийг нэмэлт хайгуул, худалдан авалт хийх замаар нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Мандал даатгал” ХК 2018 онд 27.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллажээ

“Мандал даатгал” компани 2018 оны байдлаар 71 мянган хувь хүн, албан байгууллагын эрсдэлийг даатгаж, нийт 27.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан байна.

Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 23 хувиар өссөн үзүүлэлт болж байгаа юм. Өөрөөр хэлбэл тус компани 2018 онд борлуулалтын төлөвлөгөөгөө 13 хувиар давуулан биелүүлжээ.

Хураамжийн орлогын 91 хувийг зургаан гол даатгалын бүтээгдэхүүн эзэлсэн байна. Тухайлбал, 20 хувийг барилга угсралтын даатгал, 18 хувийг эрүүл мэндийн даатгал, 17 хувийг тээврийн хэрэгслийн даатгал тус тус бүрдүүлжээ.

Харин тайлант хугацаанд нийт 7,000 гаруй даатгуулагч 4.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон талаар тус компани мэдээллээ. Энэ нь нийт нөхөн төлбөрийн зардал жилийн өмнөхөөс найман хувиар буурсан үзүүлэлт болж байна. Ийнхүү орлогоо өсгөж, зардлаа бууруулснаар 2018 онд “Мандал даатгал” компани 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, төлөвлөгөөгөө 90 хувиар давуулан биелүүлжээ. “Мандал даатгал” компани 2018 оны 9-р сард IPO гаргаж, олон нийтэд нээлттэй болсон юм.

Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй тус компанийн хувьцаа 2019 оноос эхлэн “Топ 20” индексэд шинээр багтах болсон билээ. Тус компанийн хувьцааны ханш хамгийн сүүлийн байдлаар 5,140 төгрөгт хүрснээр компанийн зах зээлийн үнэлгээ 32 тэрбум төгрөгөөр хэмжигдэх болжээ.

Энэ оны 2-р сарын эцсийн байдлаар “Мандал даатгал” компанийн 77.2 хувийг хоёр том хувьцаа эзэмшигч, үлдсэн 22.8 хувийг 800 орчим жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Mongolian Mining Corporation” 2024 онд хугацаа нь дуусах 440 сая ам.долларын үнэт цаас гаргалаа

Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Mongolian Mining Corporation” 2024 онд хугацаа нь дуусах 9.25 хувийн хүүтэй, 440 сая ам.долларын үнэт цаас гаргалаа. Тус компани нийт 740 сая ам.долларын захиалга авсан байна. Бүсээр нь харвал, хөрөнгө оруулагчид Азиас 56 хувь, АНУ-аас 25 хувь, Европ, Ойрх Дорнод, Африкийн бүсээс 19 хувь нь бүрдсэн байна. Харин 93 хувь нь сангийн менежерүүд байжээ.

Шинэ бондтой холбоотойгоор “J.P. Morgan Securities”, “Morgan Stanley” компанитай худалдах гэрээ байгуулсан талаар тус компани мэдэгдлээ. “Mongolian Mining Corporation” бондоос татан төвлөрүүлсэн хөрөнгийг хуучин үнэт цааснуудынхаа төлбөрт зарцуулахаар төлөвлөжээ. Нүүрсний ханш унасны дараа 2016 онд дефолт зарлаж байсан “Mongolian Mining Corporation” ийнхүү санхүүгийн үзүүлэлтүүдээ сайжруулахаар зорьж байна. БНХАУ-ын Засгийн газар эдийн засгийн өсөлтөө дэмжихээр зорьж байгаа аж. Мөн АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ тогтвортой хадгалах сонирхолтой байгаа энэ үед хөрөнгө оруулагчид илүү их эрсдэл үүрэх сонирхолтой байна. Тийм учраас зөвхөн I улиралд л гэхэд Азид өгөөж өндөр, эрсдэл ихтэй “Junk Bond”-уудад 30 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Тиймээс “Mongolian Mining Corporation” одоо бонд гаргаж байгаа нь тохиолдлынх биш гэдгийг шинжээчид онцолжээ.

“Mongolian Mining Corporation”-ийн зээлжих зэрэглэлийг “S&P” агентлаг “B-”, “Fitch” агентлаг “B” болгон нэмэгдүүлсэн нь бондын арилжаанд нь дэмжлэг болох боловч нүүрсний ханш буурч эхэлсэн нь эрсдэл гэж шинжээчид үзэж байна. Тус компани одоогоор 2017 онд гаргасан 194.9 сая ам.долларын үнэт цаас эзэмшигчдэдээ үнийн саналаа хүргүүлээд байгаа аж. 12.24 хувь буюу 23.9 сая ам.долларын үнэт цаас эзэмшигчид нь компанийн саналыг хүлээж авсан байна.

Үүнээс гадна 2022 онд хугацаа нь дуусах 412.5 сая ам.долларын үнэт цаасаа эргүүлэн худалдаж авахаар төлөвлөсөн бөгөөд үнийн саналаа нэмэгдүүлжээ. Одоогоор 303.2 сая ам.долларын үнэт цаас эзэмшигчид нь Mongolian Mining Corporation”-ийн тавьсан саналыг хүлээж авах сонирхолтой байгаа юм байна..

Эх сурвалж: BloombergTv.mn

ҮЦТХТ: III сард үнэт цаасны 284.5 мянган шинэ данс нээлээ

3-р сард нийт 284.5 мянган үнэт цаасны шинэ данс, 1,600 холболтын данс нээсэн гэж Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв мэдээллээ. Энэ нь 2018 онд нээж байсан нийт дансны 70 орчим хувьтай тэнцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, 2018 онд 398 мянган үнэт цаасны шинэ данс, 17 орчим мянган холболтын данс нээж байжээ.

Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн IPO-той холбоотой мэдээллүүд, олон өөр салбарын олон компани шинээр хувьцаагаа гаргаж байгаатай холбоотойгоор хөрөнгийн зах зээлийг сонирхох иргэдийн тоо нэмэгдэж байна гэж салбарын шинжээчид үзлээ. Түүнчлэн Монголын Хөрөнгийн бирж болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг мэргэжлийн байгууллагууд хөдөө орон нутгийн иргэдэд үнэт цаасны тухай ойлголтыг түгээж байгаа нь данс нээх идэвх нэмэгдэхэд нөлөөлжээ. Хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд тал бүрийн оролцоо чухал учраас хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдэд ил тод, нээлттэй байж, засаглалаа сайжруулах хэрэгтэй байгаа бол үнэт цаасны компаниуд үйлчилгээгээ аль болох хурдан, шуурхай болгох шаардлагатай ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Зах зээл дагасан уул уурхайн шинэ төслүүд

15-460 тэрбум хүртэлх төгрөгийн хөрөнгө оруулалттай нүүрсний найман төсөл байна

Нүүрс, зэс, төмрийн хүдэр, цайр зэрэг Монголоос экспортолж байгаа эрдэс бүтээгдэхүүний үнэ ханш 2019 онд тогтвортой байх төлөвтэй байна. Заримынх нь ханш өсөж байгаа бол нөгөө хэсэг нь буурахгүй нь лавтай гэж салбарынхан дүгнэлээ. Тэгвэл үүнийг дагаад 2019 онд Монгол Улсад уул уурхайн ямар ордууд олборлолтоо эхлэх төлөвлөгөөтэй байгааг тоймлоё.

"Нүүрсний зах зээл тогтвортой байгаатай холбоотойгоор нүүрсний шинэ төслүүд нэмэгдэж байна" гэж Монголын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дүгнэсэн байдаг. Тус зөвлөлийн 2-р сарын ээлжит хуралдаанаар нүүрсний гурван төслийн ТЭЗҮ-ийг хэлэлцсэн юм.

TerraCom компани Баруун ноён уул-1 хойд нүүрсний ордын баруун хэсгийг ил аргаар ашиглах ТЭЗҮ боловсруулаад буй. Нийт 2.5 сая тонн нүүрсний батлагдсан нөөцтэй энэ ордыг таван жил ашиглах аж. Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй TerraCom компани Монголоос олборлож, экспортолж байгаа нүүрснийхээ хэмжээг жилийн гурван сая тонн болгохоор зорьж байна.

Үүнээс гадна Сүхбаатар аймгийн нутагт орших "Бадмаараг хаш" компанийн Сайн хөөвөр, Говь-Алтай аймаг дахь "Арголд" компанийн хар толгой чулуун нүүрсний ордын ТЭЗҮ-ийг нэмэлт засвар хийх шаардлага тавьж хүлээн авснаа Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл мэдээлсэн.

Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээллээс харахад 2019 онд олборлолтоо эхлэхээр ТЭЗҮ-дээ тусгасан нийт 15-460 тэрбум хүртэлх төгрөгийн хөрөнгө оруулалттай нүүрсний найман төсөл байна. Эдгээрийн хагас нь чулуун нүүрс, хагас нь хүрэн нүүрс юм. Хүрэн нүүрсний ордуудын дотроос хамгийн том нь жилийн 10 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай, 460 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий Ерөөлтийн орд. Харин чулуун нүүрсний ордууд дотроос хамгийн том хөрөнгө оруулалттай нь "дадын хар толгой-2" орд байна. Дорноговь аймгийн нутагт байгаа тус ордод 21.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх бөгөөд уурхай жилд нэг сая тонн хүртэлх нүүрс олборлох хүчин чадалтай. Монгол Улс энэ онд 42 сая тонн нүүрс экспортохоор төлөвлөж байгаа зэргийг тооцож үзвэл нүүрсний салбар цаашид өргөжиж төлөв харагдаж байна. Нүүрсний салбар дахь ашиглалтын лиценз нь улсын хэмжээнд хүчин төгөлдөр байгаа ашиглалтын лицензийн 19 хувь нь юм.

Экспортын бас нэгэн гол эрдэс бүтээгдэхүүн бол төмрийн хүдэр. 2018 онд энэ төрлийн бүтээгдэхүүний экспорт 1.2 сая тонноор өссөн. Бразилд Vale компанийн төмрийн хүдрийн уурхайн далан нурж, эмгэнэлтэй том осол гарсны дараа төмрийн хүдрийн ханш огцом өссөн. Цаашид уг нөлөө зах зээлд энэ түүхий эдийг нийлүүлэгч орнуудын экспортын мөнгөн дүнд ч мэдрэгдэж эхлэх бололтой.

Өнгөрсөн жил Монголын төмрийн хүдрийн 13 уурхай бүтээгдэхүүнээ экспортолжээ. Энэ жил мөн хоёр төсөл ашиглалтад орохоор ТЭЗҮ-ээ батлуулаад байна. Түүний нэг нь Дорноговь аймгийн нутагт байрлах дарцагтын ордын зүүн хойд хэсэг. Энэ хэсэгт "Зэт Ди Эл" компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 18.42 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна.

Мөн Хэнтий аймгийн нутагт байрлах Майхан толгой ордод "Цахир цагаан гол" ХХК 9.25 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, энэ онд олборлолтоо эхлэхээр төлөвлөжээ. 2019 онд олборлолтоо эхлэх гэж байгаа алтны 21 төсөл бий.



2019 онд олборлолтоо эхлэх алтны 21 төсөл байна

Үүнээс ес нь Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт хамаарч байгаа юм. Мөн хамгийн их хөрөнгө оруулалттай төсөл нь Өмнөговь аймгийн нутагт байрлах "Макс импекс" ХХК-ийн хоримт худаг, улаан хяр алтны үндсэн орд. ТЭЗҮ-д тусгаснаар 10.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж байгаа.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд ч алтны төслөө эхлүүлэх сонирхолтой байна. Тухайлбал, Steppe Gold 2019 оны эхний хагаст багтаан Дорнод аймаг дахь алтан цагаан овоо ордын олборлолтоо эхлэхээр бэлтгэж байна. Erdene Resource Development компани алтан нар, Баянхөндий ордын олборлолтын тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ гаргаад буй. Xanadu Mines хармагтай ордын олборлолтыг энэ онд эхлэхээр тодотгосон ТЭЗҮ-дээ тусгажээ.

2018 оны экспортын бүтцийг харвал жонш өндөр өсөлттэй бүтээгдэхүүний нэг байна. Энэ онд жоншны салбарт олборлолтоо эхлүүлэхээр ТЭЗҮ батлуулсан таван төсөл бий. Үүний хоёр нь Дорноговь, үлдсэн нь Дундговь, Сүхбаатар, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байгаа юм. Эдгээрээс хамгийн том нь Сүхбаатар аймаг дахь Баян-Өргөн орд бөгөөд нийт 8.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдах аж.

Монголын жоншны экспортын гол зах зээл нь Хятад, Орос. Гэхдээ энэ салбарт төрөлжсөн судалгаа дутуу, дэд бүтцийн бэрхшээл тулгардаг гэдгийг салбарынхан анхааруулсаар ирсэн юм.

Харин экспортын зах зээлээс төдийлэн хамаарахгүй ч дотоод эрэлтдээ тулгуурлан хөгжиж байгаа нэг салбар бол шохойн чулуу. Цементийн үйлвэрийн гол түүхий эд болдог шохойн чулууны долоон орд газрыг энэ жил ашиглаж эхлэх гэж байна. АМГТГ-ын мэдээлэлд дурдсанаар эдгээр долоон төслийн хүрээнд 189 ажлын байр бий болох боломжтой.

Томоос нь дурдвал, төв аймгийн нутагт байрлах Цагаан шохойны орд. Нийт хөрөнгө оруулалт дөрвөн тэрбум төгрөг байх юм. Уурхайн хүчин чадал нь жилд 500 мянган тонн хүдэр хэмээн ТЭЗҮ-д нь тусгаж өгсөн байдаг. Мөн л энэ онд олборлолтоо эхлэхээр ТЭЗҮ батлуулсан Дорноговь аймгийн нутагт байрлах Цагаан шохойны орд 1.13 тэрбум, Ховд аймаг дахь Мянгадын орд 2.45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай.

Эрсдэлийн тухайд, энэ жилийн гол эрсдэл улс төржилт байх магадлалтай. УИХ-ын сонгуулийн өмнөх жил учир ард түмэнд таалагдах гэсэн улс төрчид ямар ч гэнэтийн мэдэгдэл хийж, нэн ялангуяа уул уурхайн салбар руу давшилж, яаж ч бужигнуулж магадгүй. Гэхдээ зах зээл таатай байна. Үүнийг илтгэх зүйл нь 2018 онд ДНБ 6.9 хувь өссөний 1.1 пунктийг нь буюу нэлээд том хувь хэмжээг нь уул уурхайн салбар дангаараа бүрдүүлсэн байдаг. Тиймээс дотоодын аливаа эрсдэлийг үл харгалзан шинэ төслүүд ийнхүү ашиглалтад орохоор төлөвлөгөөгөө хэдийнэ гаргажээ.

Эх сурвалж: Засгийн газрын мэдээ сонин

БУСАД МЭДЭЭ

АХБ: Монголын эдийн засаг 2020 он хүртэл тогтвортой өснө

Азийн хөгжлийн банк /АХБ/-ны эдийн засгийн голлох нийтлэл болох "Азийн хөгжлийн төлөв" тайлангийн энэ оны дугаарт, Монгол Улсын эдийн засгийн өсөлт ноднин 6.9 хувь байсан бол, энэ жил бага зэрэг буурч 6.7 хувь, ирэх жил 6.3 хувь болно гэж таамаглажээ. АХБ-наас өнөөдөр зохион байгуулсан хэвлэлийн хурлаар дээрх тайланг танилцуулсан юм.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт ялимгүй буурах ч дотоодын эрэлт өсөх, үйлчилгээ болон боловсруулах үйлдвэрлэл тогтворжих, хөдөө аж ахуйн салбар сэргэх зэргээс хамаараад эдийн засаг тогтвортой байна хэмээн тус тайланд дурджээ.

АХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгч Ёланда Фернандез Ломмен хэлэхдээ, "2019, 2020 оны Монгол Улсын эдийн засгийн төлөв эерэг хандлагатай байна. Ноднин Монголын эдийн засгийн өсөлт төсөөллөөс давсан. Тэр дундаа, макро эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирсан нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж макро эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд дэм болж байгаа юм. Засгийн газраас үр ашигтай бодлогыг тууштай хэрэгжүүлэх нь эдийн засгийн мөчлөг дагасан эмзэг байдлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ" хэмээв.

Инфляци ноднин дунджаар, 6.8 хувь байсан бол энэ онд 8.5 хувьд хүрэхээр байна. Энэ нь төсвийн зардал нэмэгдсэнээс үүдсэн дотоод эрэлтийн өсөлт, мөн ноднингийн сүүлийн хагаст төгрөгийн ханш суларсан болон шатахууны үнэ нэмэгдсэнтэй холбоотой. Энэ жил алтны экспорт нэмэгдэж, тээврийн салбарын орлого сайжирна гэж үзсэн байна. Уул уурхайн салбарын өсөлт болон өсөн нэмэгдэж буй махны экспорт нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт эергээр нөлөөлнө. Төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр барилгын салбарын үйл ажиллагаа сэргэх бөгөөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт ч мөн энэ онд үргэлжлэх аж. Ирэх жил инфляц буурч 7.5 хувьд тогтворжино гэж тус тайланд таамаглажээ.

АХБ-ны ахлах эдийн засагч Деклан Магий, "Энэ жил Засгийн газрын хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байна. Ингэснээр урсгал дансны алдагдал ноднин ДНБ-ий 14.6 хувьтай тэнцэж байсан бол энэ жил 9.6 хувьд хүрч буурна. Гэхдээ энэ сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн хэрэглээний зээлийн хязгаарлалттай холбоотойгоор автомашины импорт буурсан. Мөн алтны экспорт нэмэгдэх төлөвтэй байгаа нь ирэх жил урсгал дансны алдагдал ДНБ-ний 13.0 хувьд хүрч өсөх хандлагатай. Төсвийн орлого нэмэгдэж байгаа ч зардал нь мөн адил ихсээд байгаа юм. Мөн гадаад зах зээл дэх түүхий эдийн үнийн савалгаа, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт зэргээс Монголын эдийн засаг шууд хамааралтай байна. Тиймээс Засгийн газар бодлогоо зөв тодорхойлж, татварыг түүхий эдийн үнийн савалгаанаас ангид байлгах шаардлагатай. Түүнчлэн төрийн худалдан авалтыг үр ашигтай байлгахад анхаарч, төсвийн хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй салбарт оруулах хэрэгтэй" хэмээв.

Мөн тэрбээр, "Монгол Улсын төсөв таван жилийн туршид алдагдалтай явж ирсэн ч ноднин анх удаа ашигтай болсон. Энэ нь Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрээс хамааралтай. Тиймээс эдийн засгийн өсөлтөөс ирсэн орлогоо ашиглан, хуримтлал үүсгээд, түүгээрээ өрөө төлөөд явах бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй. Банкны салбарт ахиц гарсан ч чанаргүй зээл маш олон байна. Тиймээс энэ салбарт хөрөнгө оруулалт шаардлагатай" хэмээв.

Эх сурвалж: Montsame.mn



Монголбанк: Гадаад өрийн дарамт, урсгал тэнцлийн алдагдал эдийн засагт сорилт болж байна

Төв банк "Инфляцийн төлөв байдлын тайлан"-гаа танилцууллаа. 2019 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллөө нэмэгдүүлж, инфляцийн төсөөллөө бууруулсан байна. Инфляцид нөлөөлж байсан нийлүүлэлтийн хүчин зүйлс саарч, эрэлтийн хүчин зүйл нэмэгдэх төлөвтэй байна гэж үзжээ.

Гэхдээ инфляцийн богино хугацааны төсөөллийг 0.1 нэгж хувиар нэмэгдүүлсэн. Үүнд ханш суларч, импортын үнийг нэмэгдүүлэх, өмнөх жилтэй адил хэмжээний мах экспортлох тул махны үнэ, экспорт улирлын нөлөөгөөр өсөх, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ 4-р сард өсөх зэрэг таамаглалууд нөлөөлжээ.

Үүнээс өмнө Азийн Хөгжлийн банк инфляци энэ онд 8.5 хувь, 2020 онд 7.5 хувь хүрнэ гэсэн таамгийг танилцуулаад байсан юм.

Эдийн засгийн өсөлтийн тухайд төсөөллийг нэмэгдүүлж 6.9 хувьд хүргэсэн байна. Монголбанк "Цаашид өрхийн хэрэглээ нэмэгдэх, хөрөнгө оруулалтын өсөлт тогтворжих, нүүрсний экспорт нэмэгдэх, уул уурхайн бус салбарын өсөлт үргэлжлэх, бизнесийн зээлийн өсөлт нэмэгдэх" гэсэн үндэслэлээр эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нэмэгдүүлжээ.

Харин гадаад өрийн дарамт, урсгал тэнцлийн алдагдал өндөр хэвээр байгаа нь эдийн засагт тулгарсан сорилтууд болж байна. Мөн төсвийн болон мөнгөний бодлогын хараат бус байдал, FATF-ын "Саарал жагсаалт"-д орох эрсдэл эдийн засагт сорилт болж байгааг нэрлэсэн юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.